



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

Цэнхэрмандал сум

2025 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/38

Сүрьеэгийн тусламж, үйлчилгээг
багаар үзүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2024 оны "Сүрьеэгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, заавар батлах тухай" А/38 дугаар тушаалыг үндэслэн, аймгийн Эрүүл мэндийн газар, Монголын Сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооны Сүрьеэгийн тусламж, үйлчилгээнд хийсэн дэмжлэгт хяналтын зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

- Нутаг дэвсгэрийн хүн амд сүрьеэгийн цогц тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор үйлчилгээг багаар үзүүлсүгэй.
- Сүрьеэгийн цогц тусламж үйлчилгээг үзүүлэх багийн ахлагчаар М.Цэндсүрэн багийн бүрэлдэхүүнд:
Их эмч Н.Очирмаа, Д.Болор-Эрдэнэ
Эх баригч Н.Эрдэнэтуяа
Дархлаажуулалтын сувилагч Ц.Хулан
Лаборант Б.Молор-чимэг
Нийгмийн эрүүл мэндийн ажилтан Ш.Шүрэнцэцэг нарыг томилсугай.
- Тус багийн бүрэлдэхүүнд орсон эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн албан тушаалын тодорхойлолтод сүрьеэгийн чиглэлээр хариуцах ажлын чиг үүргийг тусган, батлуулахыг Дүн бүртгэгч /М.Цэндсүрэн/-д даалгасугай.
- Хариуцсан ажлын үр дүнг улирал бүр тооцож, ажил дүгнэх шалгуур үзүүлэлтэд оруулан, үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэхийг Багийн ахлагч /М.Цэндсүрэн/-д үүрэг болгосугай.
- Энэхүү тушаал гарсантай холбогдуулж Цэнхэрмандал сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн 2025 оны 01 дугаар сарын 23-ны өдрийн А/09 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЭРХЛЭГЧИЙН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ ИХ ЭМЧ Н.ОЧИРМАА

